

УЛАМЖЛАЛТ ЭМ, ЭМ НАЙРЛАГЫН СУДЛАЛД ӨРГӨН ХЭРЭГЛЭГДДЭГ ЗАРИМ НЭР ТОМЬЁНЫ ТАЙЛБАР

Ш.Болд (АШУ-ы доктор, Академич), ЭЗШУИС, УАУ-ы сургууль

Монголын уламжлалт анагаах ухаан 5000 жилийн түүхтэй хэдий ч уламжлалт анагаах ухаан хэмээх шинжлэх ухааны нэр томъёо Монголын шинжлэх ухаанд нэвтрээд 20 гаруй жилийн нүүр үзжээ. Уламжлалт анагаах ухааны нэр томъёо нь уламжлалт анагаах ухааны үйл ажиллагаа, зорилго чиглэлийг ойлгох, дэлгэрүүлэн хөгжүүлэх, олон түмэнд таниулах, дэлхий нийтэд түгээхэд онцгой үүрэгтэй. Тиймээс уламжлалт анагаах ухааны нэр томъёо нь тухайн шинжлэх ухааны суурь болон хавсарга шинжлэх ухааны салбарт хамаарагдах ойлголтын хүрээнээс хальж хүний тухай орчин үеийн мэдлэгийн хүрээнд ихээхэн чухал байр суурь эзлэх болжээ.

Аливаа шинжлэх ухааны салбарын нэр томъёо нь уг үндэстний хэлний бүрэлдэхүүн хэсэг бөгөөд өөрийн хуулиар хөгжиж, нийгмийн хөгжлийн үйл явцтай зэрэгцэн өөрчлөгдөж байдаг. Нэр томъёоны гарал үүслийг тухайн шинжлэх ухааны түүхэн хөгжлөөс эрж хайх нь зүй ёсны хэрэг. Уламжлалт анагаах ухааны нэр томъёо ч уг салбарын үүссэн үеэс эхлэн үг, холбоо үг болон үүсч, хөгжиж өргөжин тэлсээр иржээ.

Сүүлийн жилүүдэд уламжлалт анагаах ухааны нэр томъёо шинээр үүсэн хөгжиж анагаах ухааны чиглэлийн нэр томъёогоор баяжигдан нэмэгдэх хандлагатай болж байна. Мөн хуучин нэр томъёо ч зохицохоо болих тал ч ажиглагдаж байна. Тиймээс уламжлалт анагаах ухааны нэр томъёог ч эмхлэн цэгцлэх шаардлагатай байгаа юм. Энэ удаа бид уламжлалт анагаах ухааны үндсэн салбар болох эм судлал, эм найрлагын судлалтай холбоотой суурь ойлголтыг багтаасан зарим нэр томъёог сонгон авч, судалгаа хийж тайлбарлахыг зорилоо.

1. АМАРЛИУЛАГЧ ЭМ

Эм уулгасан цагт гэмийг өөрийн оронд нь амарлиулан үйлдэгчийг амирлуулагч хэлнэ. Амарлиулагч эмийн өвөрмөц онцлог нь гэмийг өөрийн оронд нь тэгшитгэхэд оршино. Амарлиулагч эмийн товч гэж “Хойд үндэс”-ийн дөрвөн товчийн доторх эм уулгаж дотор (гадар) өвчнийг амарлиулж үйлдэх аргыг үзүүлснийг хэлмой. Амарлиулагч тавд: тан, талх, үрэл, зуурмал, тосон эм багтана.

Энэхүү амарлиулагч таван эмийн хооронд цагийн барилдлага, үйлдэлийн барилдлага байх тул дэлгэрэнгүйг мэдэхийг хүсэгчид “Хойд үндэс”-ийн тайлбар үзэгтүн хэмээсэн байдаг.

2. АМАРЛИУЛАГЧ ЭМИЙН НАЙМАН АЙМАГ

Тан, талх, үрэл, зуурмал, тосон эм, үнсэн эм, ханд эм, архин эм зэрэг найм.

3. АМАРЛИУЛАГЧ ЭМИЙН НАЙМАН АЙМАГ

1/ Тан, 2/ талх, 3/ үрэл, 4/ зуурмал, 5/ тосон эм, 6/ үнсэн эм, 7/ ханд эм, 8/ архин эм.

4. АМТ

Идээ, ундаа хүний амтлах эрхтэнд мэдрэгдэх, амтлах эрхтэнд үүсэх сэрэл

5. АМТЫН НАЙРЛАГА

Эмийн гол амт болон амтанд дагалдсан найман чадал, арван долоон эрдмийг гол болгоно. Хий, шар, бадган гурван гэмийн урвалтын аль нэгэн хувиралтыг дарж, тэгшитгэх чадал, үйлдлийн бүрэлдүүлэн бүхий найруулсан эмийг хэлнэ. Үүнд дан амтын найрлага, хоёр зүйлийн амтын найрлага, гурван зүйлийн амтын найрлага, дөрвөн зүйлийн амтын найрлага, таван зүйлийн амтын найрлага, зургаан зүйлийн амтын найрлага гэж олон зүйлээр найруулдаг. Жишээлбэл дэгд-3-ын тан бол дан амтын найрлага, индра-4-ийн тан хавсарсан амтын найрлага юм.

6. АМТЫН ЕРӨНХИЙ ҮЙЛДЭЛ

Эмийн түүхий эдийн үндсэн зургаан амт нь тус бүрийн онцлогоосоо шалтгаалан хий, шар, бадганыг дарах ба үүсгэх нийтлэг үйлдлийг хэлнэ. Амтлаг амт нь хий, шарыг дарж бадганыг үүсгэнэ. Исгэлэн, давслаг, гошуун амт нь хий, бадганыг дарж шарыг, гашуун, эхүүн амт нь шарыг дарж хий, бадганыг үүсгэх чадалтай юм.

7. АМТЫН ЗУРГААН ШҮТЭЭН

Шороо-ус хоёр амтлаг, гал-шороо хоёр давслаг, ус- хий хоёр гашуун, гал-хий хоёр халуун, шороо-хий хоёр эхүүн зэрэг зургаа.

8. АМТЫН НАЙРЛАГА

Эмийн түүхий эдийн үндсэн амт болон амтанд дагалдсан найман чадал, арван долоон эрдмээр хий, шар, бадганы хувиралтыг дарж, тэгшитгэх чадал, үйлдлийг бүрэлдүүлэн найруулсан найрлагыг хэлнэ. Үүнд: дан амтын найрлага, хоёр зүйлийн амтын найрлага, гурван зүйлийн амтын найрлага, дөрвөн зүйлийн амтын найрлага, таван зүйлийн амтын найрлага, зургаан зүйлийн амтын найрлага

гэх мэтээр найруулдаг. Жишээлбэл Дэгд-3-ын тан дан амтын найрлага харин Индра-4-ийн тан бол хавсарсан амтын найрлага болдог.

9. АРВАН ДОЛООН ЭРДЭМ

Таван махбодоос үүссэн эм бүхэнд түгээмэл агуулагдах хийг арилгах таван эрдэм, шарыг арилгах зургаан эрдэм, бадганыг арилгах зургаан эрдэм тэргүүтэн эмийн арван долоон эрдмийн хураангуй нэр. Үүнд: зөөлөн, хүнд, бүлээн, тослог, бат, хүйтэн, мохдог, сэрүүн, эелдэг, шингэн, хуурай, нүнжиггүй, халуун, хөнгөн, хурц, ширүүн, хөдлөнгө зэрэг болно. Эмийн эрдэм бол таван махбодоос үүссэн, зураан амт бүрэлдсэн бөгөөд аль нэгийг хүртсэн цагт өөрийн махбодын бэлгэ чанар зохилдмой. Ингэвээс бие махбодыг төлжүүлэх, үл зохилдвоос дарах чадалтай болой.

10. ГАЛ ЭМ

Ерөнхийдөө халуун, бүлээн чанартай эмийн зүйл багтах бөгөөд мөн галаар үйлдэгдсэн эм, галаас гарсан эм зэрэг багтана. Галаар үйлдэгдсэн эм гэдэг нь үнсэн эмийн зүйлийг хэлнэ. Галаас гарсан эм гэдэг нь утаа зэргээр үйлдэгдсэн эмийн зүйлийг хэлнэ.

11. ГУРВАН АМТЛАГ

1. Чихэр, бал, бурам гурав.
2. Чихэр, бал, бурам гурав нь шим авахуулах, хүчжүүлэх, тамиржуулах чадалтай учир хүчжүүлэх найрлаганд хольж идүүлнэ. Заримдаа бал, бурам, сүү гурвыг 3 амттан гэж бас хэлдэг.

12. ГУРВАН ЗҮЙЛИЙН ШИМТ ЯС

Хонины далны бариул, борви, ахар сүүлний яс гурав.

13. ГУРВАН ЗҮЙЛИЙН ЭМИЙН ХӨЛӨГ

Бурам, цагаан чихэр, бал гурав.

14. ЕРӨНДГИЙН ЗУРГААН ЭМ

Ямар нэгэн өвчинд гол ерөндөг болдог эмүүдийн хураангуйлсан нэр болно. Тухайлбал эрдэнийн найрлага доторх бурууг дарах зургаан эм: Бивлин, хар чинжүү, жонш, арц, хужир, чацаргана зургааг хэлнэ.

15. ЕРӨНДӨГ

1. Муу юмыг номхотгон дийлэгч.
2. Өвчнийг амарлиулах, арилгахад хэрэглэдэг идээ, явдал мөр, эм, засал дөрвийн нэр.

16. ЗУРГААН АМТ

1/ Амтлаг, 2/ исгэлэн, 3/ давслаг, 4/ гашуун, 5/ гошуун, 6/ эхүүнийг үндсэн зургаан амт гэнэ.

17. МАНЖ

Хорол гэдэг. Эм, танг нунтагладаг чулуун, ширмэн савны нэр.

18. НАЙМАН ЧАДАЛ

Эмийн эрдэм бүгдийн шимийг хүнд, тослог, сэрүүн, мохдог, хөнгөн, ширүүн, халуун, хурц наймаар хураангуйлсан нэр. Эхний дөрвөн чадлаар хий, шарыг, дараагийн дөрвөн чадлаар бадганыг арилгана.

1. Хүнд: Амтанд дагалдсан найман чадлын нэг. Хийн хөнгөн бэлгэ чанарыг дарж, бадганы хүнд бэлгэ чанарыг төлжүүлэх өвөрмөц чадал.

2. Тослог: Амтанд дагалдсан найман чадлын нэг. Хийн нарийн, чийрэг, бэлгэ чанарыг дарж, шар, бадганы тослог бэлгэ чанарыг төлжүүлэх өвөрмөц чадал.

3. Хүйтэн: Амтанд дагалдсан найман чадлын нэг. Шарын халуун бэлгэ чанарыг дарж, бадган, хийн хүйтэн, сэрүүн бэлгэ чанарыг төлжүүлэх өвөрмөц чадал.

4. Мохдог: Амтанд дагалдсан найман чадлын нэг. Шарын хурц бэлгэ чанарыг дарж, бадганы мохдог бэлгэ чанарыг төлжүүлэх өвөрмөц чадал.

5. Хөнгөн: Амтанд дагалдсан найман чадлын нэг. Бадганы хүнд бэлгэ чанарыг дарж, хийн хөнгөн бэлгэ чанарыг төлжүүлэх өвөрмөц чадал.

6. Ширүүн: Амтанд дагалдсан найман чадлын нэг. Бадганы зөөлөн наалдангуй бэлгэ чанарыг дарж, хийн ширүүн бэлгэ чанарыг төлжүүлэх өвөрмөц чадал.

7. Халуун: Амтанд дагалдсан найман чадлын нэг. Бадганы хүйтэн, хийн сэрүүн бэлгэ чанарыг дарж, шарын халуун бэлгэ чанарыг төлжүүлэх өвөрмөц чадал.

8. Хурц: Амтанд дагалдсан найман чадлын нэг. Бадганы мохдог бэлгэ чанарыг дарж, шарын хурц бэлгэ чанарыг төлжүүлэх өвөрмөц чадалтай болой.